



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ ТӨҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/57/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 261885 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул  
Утас: 261740 Цахим хаяг: [erdenezulb@audit.mn](mailto:erdenezulb@audit.mn)  
Гэрээгээр гүйцэтгэсэн Нийслэл аудит ХХК-ийн  
Захирал Т.Сугарсүрэн  
Утас: 318918 Цахим хаяг: [info@niislelaudit.mn](mailto:info@niislelaudit.mn)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	6
3. Аудитын тайлан .....	7
3.1 Ерөнхий зүйл .....	7
3.2 Дотоод хяналт .....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	7
3.4 Материаллаг байдал .....	8
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	10
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	11
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
8. Аудитын илрүүлэлт .....	13
8.1 Залруулсан алдаа .....	13
8.2 Албан шаардлага .....	13
8.3 Зөвлөмж .....	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ХХБ	Худалдаа хөгжлийн банк



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ  
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ  
О.ДАВААСАМБУУ ТАНАА

2022.03.15

№ 07/618

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хараат бус аудиторын тайлан

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон зүйл

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын үндсэн үйлчилгээний буюу шинжилгээний ажлын нийт авлага нь 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 1,000.5 сая төгрөг байгаагаас 56.7 хувь буюу 432.7 сая төгрөгийн авлага нь тайлант жилд шинээр үүссэн, бусад 567.8 сая төгрөгийн авлага нь 2-14 жилийн насжилттай байна.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-д хийгддэг шинжилгээний ажлын эцсийн дүгнэлт 7 хоногийн дотор, технологийн туршилтын ажлын тайлан 3-6 сарын дотор бэлэн болж эцсийн төлбөрийг нэхэмжлэх боломжтой байдаг боловч хуримтлагдсан авлага үүссэн байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 23-ны

өдрийн 639 дүгээр тушаалаар Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 3,938.0 сая төгрөгөөр зардлыг 3,853.0 сая төгрөгөөр төсөвлөж, гүйцэтгэлээр 3,879.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,173.6 сая төгрөгийн зардал гарган 294.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын төлөвлөгөө 58.5 сая төгрөгөөр тасарсан, нийт зарлага 320.6 сая төгрөгөөр хэтэрсэн нь Ковид-19 цар тахлын улмаас улс орнуудад хилийн хориг, тусгаарлалтыг удаан хугацаагаар үргэлжлүүлснээс дэлхийн зах зээл дээр түлш, түүхий эд материал, тээвэр ложистикийн хямрал үүсч, шинжилгээний ажлын гол түүхий эд болох урвалж бодисын үнэ 4.6-80.5 хувиар өссөн, хөл хориотой холбоотойгоор шинжилгээний ажлын тоо хэмжээ багасч үүнийг даган орлого буурсантай холбоотой байна.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн тайланд үйл ажиллагааны үндсэн 3 зорилтын 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн тайланд баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
		/төгрөгөөр/	
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгө	105,251,569.17	152,590,469.86
1.1.2	Дансны авлага	1,179,020,367.00	1,398,874,326.66
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,191,488.04	12,599,441.20
1.1.6	Бараа материал	1,524,819,848.67	1,595,921,419.08
1.1.7	Урдчилж төлсөн зардал тооцоо	29,138,961.19	36,863,961.19
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,839,422,234.07</b>	<b>3,196,849,617.99</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	10,083,352,689.04	9,354,499,963.78
1.2.2	Биет бус хөрөнгө	158,357,112.05	145,082,655.09
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>10,241,709,801.09</b>	<b>9,499,582,618.87</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,081,132,035.16</b>	<b>12,696,432,236.86</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	134,803,752.47	66,232,603.70
2.1.1.2	Цалингийн өглөг	1,002,309.00	0.00
2.1.1.3	Татварын өр	130,343,706.69	32,714,860.39
2.1.1.4	НДШ-ийн өглөг	127,191,337.70	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	361,563,442.61	567,581,496.66
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>754,904,548.47</b>	<b>666,528,960.75</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>754,904,548.47</b>	<b>666,528,960.75</b>
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Төрийн өмч	4,770,388,463.67	4,770,388,463.67
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,985,275,518.69	5,985,275,518.69
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	978,235,676.75	978,235,676.75
2.3.9	Хуримтлагдсан ашиг	592,327,827.58	296,003,617.00
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>12,326,227,486.69</b>	<b>12,029,903,276.11</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>13,081,132,035.16</b>	<b>12,696,432,236.86</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
		/төгрөгөөр/	
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>3,511,428,625.39</b>	<b>3,877,566,383.89</b>
2	Борлуулалтын өртөг	3,11,933,414.82	3,581,520,977.94
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>391,495,210.57</b>	<b>296,045,405.95</b>
5	Хүүгийн орлого	3,347,378.42	0.00
8	Бусад орлого	722,730.27	1,917,347.77
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	1,522,200.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	247,405,888.44	568,155,298.58
12	Бусад зардал	19,051,062.06	22,082,534.00
13	Гадаад валютгийн ханшийн зөрүүтэй олз (гарз)	2,695,418.04	(290,227.86)
18	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>131,803,786.80</b>	<b>(294,087,506.72)</b>
19	Орлогын татварын зардал	13,180,378.68	0.00
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>118,623,408.12</b>	<b>(294,087,506.72)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын ашиг ( алдагдал )</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>118,623,408.12</b>	<b>(294,087,506.72)</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>118,623,408.12</b>	<b>(294,087,506.72)</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>4,770,388,463.67</b>	<b>5,985,275,518.69</b>	<b>978,235,676.75</b>	<b>473,704,419.46</b>	<b>12,207,604,078.57</b>
2	Залруулсан үлдэгдэл		5,985,275,518.69	978,235,676.75	473,704,419.46	12,207,604,078.57
3	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	118,623,408.12	118,623,408.12
4	<b>2020 оны 12-р сарын 31- ээрх үлдэгдэл</b>	<b>4,770,388,463.67</b>	<b>5,985,275,518.69</b>	<b>978,235,676.75</b>	<b>592,327,827.58</b>	<b>12,326,227,486.69</b>
5	Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	2,236,703.86	2,236,703.86
6	Залруулсан үлдэгдэл	4,770,388,463.67	5,985,275,518.69	978,235,676.75	590,091,123.72	12,323,990,782.83
7	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	(294,087,506.72)	(294,087,506.72)
8	<b>2021 оны 12-р сарын 31- ээрх үлдэгдэл</b>	<b>4,770,388,463.67</b>	<b>5,985,275,518.69</b>	<b>978,235,676.75</b>	<b>296,003,617.00</b>	<b>12,029,903,276.11</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>3,449,492,061.12</b>	<b>4,491,387,308.83</b>
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсний орлого	3,448,016,435.19	4,483,208,076.29
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	315,720.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,159,905.93	8,179,232.54
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>4,066,423,582.61</b>	<b>4,382,877,241.00</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,598,039,509.00	1,639,877,241.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	194,200,907.13	674,461,377.76
1.2.3	Бараа материал худалдаг авахад төлсөн	1,870,914,384.37	1,452,662,074.41
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	374,400,219.77	575,524,592.87
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	115,830.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	28,868,562.34	40,177,817.16
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(616,931,521.49)</b>	<b>108,568,375.63</b>
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>3,347,378.42</b>	<b>0.00</b>
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	3,347,378.42	0.00
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>0.00</b>	<b>60,950,900.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	56,325,900.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	4,625,000.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,347,378.42</b>	
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>2,499,496.23</b>	<b>100,956.15</b>
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	2,499,496.23	100,956.15
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>(123,947.02)</b>	<b>(379,531.09)</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	0.00	0.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(123,947.02)	(379,531.09)
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>2,375,549.21</b>	<b>(278,574.94)</b>
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(611,208,593.86)	47,338,900.69
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	716,460,163.03	105,251,569.17
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	105,251,596.17	152,590,469.86

**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

№	Үзүүлэлтүүд	2020	2021			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	<b>Нийт орлого</b>	<b>3,517,815.2</b>	<b>3,938,000.0</b>	<b>3,879,483.7</b>	<b>(58,516.3)</b>	<b>98.5</b>
1	Шинжилгээний ажлын орлого	3,354,074.2	3,653,000.0	3,657,987.4	4,987.4	100.1
	Чулуун бүтээгдэхүүн борлуулалт орлого	641,32.0	100,000.0	32,512.7	(67,487.3)	32.5
	Стандарт загварын борлуулалт орлого	72,107.1	150,000.0	161,285.3	11,285.3	107.5
	Бусад орлого	25,185.3	35,000.0	27,698.3	(7,301.7)	79.1
2	<b>Нийт зардал</b>	<b>3,386,390.4</b>	<b>3,853,000.0</b>	<b>4,173,571.2</b>	<b>320,571.2</b>	<b>108.3</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	247,405.9	235,000.0	568,155.3	333,155.4	241.8
3	Татварын өмнөх ашиг, алдагдал	131,424.8	85,000.0	(294,087.5)	(379,087.5)	0.0
4	Цэвэр ашиг (алдагдал)	118,282.3	76,500.0	(294,087.5)	(370,587.5)	0.0
5	Төрийн өмчийн ноогдол ашиг	17,793.5	11,475.0	0.0	(11,475.0)	0.0
6	Нийт ажиллагсдын тоо	158	158	166	8	105.1
7	Нийт цалингийн сан	2,168,033.6	2,150,000.0	2,109,376.1	(40,623.9)	98.1
8	Нэг ажилтны дундаж цалин	1,143.5	1,134.0	1,032.2	(101.8)	91.0
9	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.96	0.98	1.08	0.1	110.0
10	Хөрөнгө оруулалт	55,901.5	304,690.0	66,604.4	(238,085.6)	21.8
11	Нийт төсвийн төлбөрт	671,000	693,800.0	1,326,982.7	633,182.7	191.3
12	Нийт авлага	1,180,211.8	800,000.0	1,411,473.7	598,874.3	174.9
13	Нийт өглөг	754,904.5	800,000.0	666,529.0	(133,471.0)	83.3
14	Үүнээс : Богино хугацаат өглөг	754,904.5	800,000.0	666,529.0	(133,471.0)	83.3

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Геологийн төв лабораторийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өнгөт чулууны цехийн бүтээгдэхүүний өртөг болон үнэ тооцох аргачлал боловсруулах, 2018 онд хүлээж авсан боловч үйл ажиллагаа нь жигдрээгүй лабораторийн шинжилгээний тоног төхөөрөмжийг удирдлагаар хангах программыг ажиллагаанд оруулах, нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцож, төвлөрүүлэх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 15-наас 2022 оны 3 дугаар сарын 18-ны хооронд Нийслэл-Аудит ХХК-ийн аудитор Л.Сарантуяа, аудитын шинжээч Д.Чулуунбаатар, аудиторын туслах М.Байгалмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Л.Ганзориг, захирал Т.Сугарсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Геологийн төв лаборатори ТӨҮГ нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Нийслэл Аудит ХХК-д 2022 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 91 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн. Учир нь Геологийн төв лаборатори ТӨҮГ нь 2021 оны 11 сард дотоод аудитортой болсон бөгөөд 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд ямар нэгэн дотоод хяналтын үйл ажиллагаа явуулаагүй болно.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч зарим үзүүлэлтүүд нь тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй, өнгөт чулууны үйлдвэрлэлийн хэсгийн нягтлан бодох бүртгэлийн аргачлал тусгагдаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар 2021 оны төгсгөлд шинээр ажиллаж эхэлсэн дотоод аудиторын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах нөхцөл үүсээгүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.



Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 3,386.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 50.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Геологийн төв лабораторийн зорилго нь Монгол улсын нутаг дэвсгэрт хийгдэж байгаа бүх төрлийн геологийн судалгаа шинжилгээ, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт ба гаалийн хяналтыг иж бүрнээр нь дотооддоо олон улсын түвшинд хийж гүйцэтгэхэд оршино. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Геологийн төв лаборатори нь төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийг 100 хувийг төр эзэмшиж байна.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрдсийн түүхий эдийн тоон ба хагас тоон шинжилгээ
- Бодисын найрлагын судалгаа
- Ашигт малтмалын баяжигдах шинж чанарын лаборатори технологийн туршилт
- Хүдрийн бус ашигт малтмалын физик механикийн шинж чанарын судалгаа
- Нүүрсний шинжилгээ
- Байгаль орчны судалгаа, шинжилгээ (цианид, мөнгөн ус, хүнд металл)
- Стандартчилсан загвар, аттестатчилсан стандартчилсан загварын (АСЗ) үйлдвэрлэл
- Ажиллагсдыг мэргэшүүлэх сургалт, их дээд сургуулийн оюутны дадлага, сургалт
- Лаборатори хоорондын гадаад хяналт, экспертиз шинжилгээ
- Чулуун бүтээгдэхүүн, бэлэг дурсгалын зүйлийн үйлдвэрлэл

### 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Геологийн төв лаборатори нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр геологийн зураглал, хайгуул шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, эрдсийн задлан шинжилгээгээр эцсийн үр дүнг тодорхойлох зорилгоор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1957 оны арван нэгдүгээр сарын 27-ны өдрийн 461 дүгээр тогтоолоор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Геологи Шинжилгээний Удирдах Газрын харьяанд (ГШУГ) “Эрдэм Шинжилгээний Төв Лаборатори” нэрээр анх байгуулагдсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 663 тогтоолоор баталсан Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д: “Төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь үйлдвэрийн газрын захирлыг томилж, чөлөөлнө” гэж заасны дагуу ТӨБЗГ-ын даргын 2021 оны 09 сарын 08-ны өдрийн 352 дугаар тогтоолоор О.Даваасамбууг Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын захирлаар томилсон.

ТӨБЗГ, Үндэсний геологийн алба, Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын захиралтай байгуулсан гурвалсан Контрактын 4.1-д Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын Захирлын албан тушаалын сарын үндсэн цалинг 2.8 сая төгрөгөөр тогтоосон байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна.

Энэ хүрээнд Геологийн төв лаборатори ТӨҮГ нь “Олон улсад өрсөлдөхүйц үндэсний лабораторийг хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилготой байгууллагын ойрын ирээдүйн 5 жилийн хөгжлийн бодлогыг тусгасан төсөл боловсруулж хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг эхлүүлж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу 2020 оны аудитын зөвлөмжийн дагуу 2014-2016 онд тогтоогдсон бодит байдалд нийцэхгүй байгаа шинжилгээний ажлын гүйцэтгэлээр цалин олгох нормчлолыг өөрчилж тогтмол цалингийн шинэ системийг тогтоосноор өнгөрсөн онтой харьцуулахад цалингийн зардал 138,7 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Байгууллагын удирдлага шинэчлэгдсэнтэй холбоотойгоор ТӨБЗГ-ын 2021 оны 11 сарын 11-ний өдрийн “Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтцийн схем, албан тушаалын жагсаалт батлах тухай” 480 тоот тогтоолын дагуу Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын захирлын 2021 оны 11 сарын 22-ны өдрийн А/85 тоот тушаалаар бүтэц зохион байгуулалт, албан тушаалын жагсаалт, үндсэн цалингийн сүлжээг шинэчилж баталсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- **ААНОАТ-ын тухай хууль**-д шинээр орсон заалт: 13.2.5.”Ёслол хүндэтгэлийн арга хэмжээний зардал нь тухайн татварын жилд Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээ болон онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа ажиллагчдад олгосон цалингийн зардлын нийт дүнгийн 5 хувиас хэтрэхгүй байх”;
- **Нийгмийн даатгалын тухай хууль**-ийн а/ 15 дугаар зүйл “Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, төлөх хугацаа”-д 2021 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг өөрчилсөн.

- б/32 дугаар зүйл."Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого"-ийн 32.1 дүгээр заалтад нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг Хөдөлмөрийн тухай хуулийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлд заасан цалин хөлс, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд заасан олговор; гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчилсөн.
- **Татварын ерөнхий хууль**-ийн 64 дүгээр зүйл "Авлага битүүмжлэх, татварын өр гаргуулах"-д 64.6.6 дугаарт "Цалин хөлснөөс татварын өрийг гаргуулахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн 119.2-т заасныг "Ажилтны нэг сарын цалин хөлснөөс хийх нийт суутгал нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг хассан цалин хөлсний дүнгийн 20 хувиас, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, эсхүл хэд, хэдэн суутгал зэрэг хийх бол цалин хөлсний 50 хувиас хэтрэхгүй байна" баримтална" гэсэн заалт шинээр нэмэгдсэн.

#### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	105,251.6	152,590.5	47,338.9
Авлага	1,180,211.8	1,411,473.7	231,261.9
Урьдчилгаа	29,139.0	36,864.0	7,725.0
Бараа материал	1,524,819.8	1,595,921.4	71,101.6
Үндсэн хөрөнгө	10,083,352.7	9,354,500.0	(728,852.7)
Биет бус хөрөнгө	158,357.1	145,082.6	(13,274.5)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>13,081,132.0</b>	<b>12,696,432.2</b>	<b>(384,699.8)</b>
Богино хугацаат өглөг	754,904.5	666,528.9	(88,375.6)
Өр төлбөрийн дүн	<b>754,904.5</b>	<b>666,528.9</b>	<b>(88,375.6)</b>
Эздийн өмч	12,326,227.5	12,029,903.3	(296,324.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>13,081,132.0</b>	<b>12,696,432.2</b>	<b>(384,699.8)</b>

Өмнөх оны үзүүлэлтүүдээс дараах дансуудын үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- ХХБ, Голомт банк дахь 5 харилцах дансны нийт үлдэгдэл 43.4 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- Авлагын нийт үлдэгдэл 1,411.5 сая төгрөг байгаагаас төлөгдөх хугацаандаа байгаа авлага 590.7 сая буюу нийт авлагын 41.8 хувийг эзэлж байна. Бусад авлагын насжилтаар авч үзэхэд 10-аас дээш жил болсон авлага 59.1 сая буюу 4.2 хувийг эзэлж байгаа бол 3-9 жил болсон авлага 761.7 сая төгрөг буюу нийт авлагын 54.0 хувийг эзэлж байна. Авлагын бүтцийг авч үзэхэд нийт авлагын 86.8 хувийг байгууллагын үндсэн үйл ажиллагаа болох шинжилгээний ажлын авлага эзэлж байна. Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 219.8 сая төгрөгөөр нэмэгдсэнд шинжилгээний ажлын тоо хэмжээ өссөн нь гол нөлөөлөх хүчин зүйл болсон.
- Урьдчилгаа дансанд 2019 онд үүссэн 19.9 сая төгрөгийн винтеляторын үнийн урьдчилгааны үнэ тусгагдсан байх бөгөөд тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй, бэлтгэн нийлүүлэгч нь тодорхойгүй байгаа тул бусад эзэн холбогдогчгүй авлагыг барагдуулах

жагсаалтад оруулсан байна. Бусад 17.0 сая төгрөг нь 2021 онд үүссэн лабораторийн тоног төхөөрөмжийн засварын үйлчилгээний гэрээний урьдчилгааны үнэ болно.

- Бараа материалын дансны үлдэгдэл 1,595.9 сая төгрөг болж 71.1 сая төгрөгөөр өссөн нь бараа материалын худалдан авалт, үнийн өсөлтөөс шалтгаалжээ. Тайлант онд 589,4 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт хийсэн байна. Үүнийг судалж үзэхэд 357.6 сая төгрөгийн буюу 60.7 хувийг сонгон шалгаруулалтаар худалдаж авсан шинжилгээний ажилд хэрэглэгдэх шууд материал буюу урвалж бодисууд эзэлж байгаа бөгөөд 88.7 хувийг зарцуулсан.
- Тайлант онд 66.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шинээр худалдан авсан бөгөөд жилийн эцсийн тооллогоор актлагдах үндсэн хөрөнгийн шийдвэр 2021 онд багтаж ТӨБЗГ-аас ирээгүй байгаа тул данснаас хасаагүй байна.
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 666.5 сая төгрөгийн үлдэгдэл байгаа бөгөөд тайлант онд Нийгмийн даатгалын шимтгэлийн 127.2 сая төгрөгийн, НӨАТ болон бусад татварын 97.6 сая төгрөгийн өрийг барагдуулжээ.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Геологийн төв лаборатори ТӨҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 639 дүгээр тушаалаар Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан ба нийт орлогыг 3,938.0 сая төгрөгөөр зардлыг 3,853.0 сая төгрөгөөр тогтоожээ.

Гүйцэтгэлээр 3,879.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,173.6 сая төгрөгийн зардал гарган, 294.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Алдагдалтай ажилласан шалтгаан нь нийт орлого 8.5 хувиар буюу 58.5 сая төгрөгөөр тасарч, нийт зардал 8.0 хувиар буюу 320.5 сая төгрөгөөр хэтэрсэнтэй холбоотой байна.

Зардал өссөн нь дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр түүхий эдийн хомсдол үүсч лабораторийн шинжилгээнд хэрэглэгдэх урвалж бодисуудын үнэ нэр төрлөөсөө хамаарч 4.6-аас 80.5 хувь өссөн, өнгөрсөн оны бодит гүйцэтгэл, үнийн өөрчлөлтийн судалгааг дутуу хийснээр зардлын зарим үзүүлэлтийг үндэслэлгүй төлөвлөсөн зэрэгтэй холбоотой байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А-1/1138 тоот шийдвэрийн дагуу 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгээр 11.8 сая төгрөгийн ногдол ашгийг ТӨБЗГ-т төвлөрүүлжээ.

### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 9 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Геологийн төв лаборатори ТӨҮГ нь тайлант онд нийт 7,390.2 сая төгрөгийн 305 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 248.6 сая төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд зөвлөмж өгөх.

## 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд хийгдсэн худалдан авах ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн эсэхийг шалгахад лабораторийн үндсэн үйл ажиллагаанд хэрэглэх 26.8 сая төгрөгийн үнэ бүхий дээж сэгсрэгч тавцан бүхий ширээ, тоног төхөөрөмжийг үнийн харьцуулалт хийлгүй шууд худалдан авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн заалт, 26.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг үнийн харьцуулалтын санал авалгүйгээр шууд худалдан авсан нь ТБОНӨБАҮХАТХ-ийн холбогдох заалтад нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 103.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 66.9 сая төгрөгийг залруулж зөрчлийг арилгасан, 36.3 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 22.6 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

*/мянган төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	7	22,656.3	7	22,656.3	-	-	100.0
Нийт дүн	7	22,656.3	7	22,656.3	-	-	100.0

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар анхаарал татсан доорх асуудлуудыг дараагийн аудитаар хамруулан горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

- Санхүүгийн тайланд тусгагдсан 2-16 жил болсон хуримтлагдсан авлагыг барагдуулах, эзэн хариуцагчийг тогтоох ажлын явцын гүйцэтгэлтэй танилцах.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 344.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 26.3 сая төгрөгийн алдааг залруулж, 36.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 255.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй 42.8 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 50.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 7.7 сая төгрөгөөр бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой үндэслэлгүйгээр ажлаас халагдсан нь тогтоогдсон 2 ажилтанд Сонгино хайрхан дүүргийн шүүхийн шийдвэрээр байгууллагаас төлсөн 26.2 сая төгрөгийн нөхөн төлбөрийг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас авах авлагаар бүртгэж тайлагнасныг залруулсан.

### 8.2 Албан шаардлага

1. УУХҮЯам, Бодь электроникс ХХК-ийн хооронд байгуулагдсан 2018 оны 03/2288 тоот сонгон шалгаруулах гэрээний дагуу Геологийн төв лаборатори ТӨҮГ-д нийлүүлэгдсэн лабораторийн тоног төхөөрөмжийн мэдээллийг нэгдсэн удирдлагаар хангах зориулалт бүхий 32.3 сая төгрөгийн үнэ бүхий программ хангамжийн тохиргоо хийгдээгүйгээс үйл ажиллагаандаа ашиглаж эхлээгүй, хүлээж авсан акт байхгүй, нягтлан бодох бүртгэлд туссан, биет бус хөрөнгийн дүнг элэгдүүлэн бүртгэж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. 1. “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй: 1/ өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүрэг 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлан дахь биет бус хөрөнгийн элэгдлийн тооцооллыг зогсоож, программ хангамжийг яаралтай ашиглалтанд оруулах албан шаардлага хүргүүлэх.

2. Өнгөт чулууны цехийн бүтээгдэхүүний өртөг болон борлуулах үнэ тооцох журамласан аргачлал, эрх зүйн акт байхгүй, 2016 оноос хойш бүтээгдэхүүнийг борлуулах үнийг шинэчлээгүй, зах зээлийн үнээс доогуур тогтоодог, нийт 4.0 сая төгрөгийн өртөгтэй 4 ширхэг чүнчигноров хөөрөг, гоёл чимэглэлийн зүйлсийг 2.7 сая төгрөгөөр буюу өртгөөс нь бага үнээр зарж борлуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1 дугаар заалт: “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл Аж ахуйн нэгжийн захирлын эд хөрөнгийн эрх үүрэг. 9 дүгээр заалт: “ улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох; 10 дугаар заалт: эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах”-ыг зөрчиж Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүтээгдэхүүнийг өртгөөс нь бага үнээр худалдан борлуулах зөрчлийг дахин гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3. Нийт 26.8 сая төгрөгийн үнэ бүхий дээж сэгсрэгч тавцан бүхий ширээ, тоног төхөөрөмжийг үнийн харьцуулалт хийлгүй шууд худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 1 дүгээр заалт: "Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна" 33 дугаар зүйлийн 1 дүгээр заалт: "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно" гэж заасныг тус тус зөрчиж Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

### 8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Шинжилгээний орлогын хуримтлагдсан авлагатай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд тусгагдсан 1,000.5 сая төгрөгийн шинжилгээний авлагын 49 хувь буюу 490.2 сая төгрөгийн авлага нь төлөгдөх магадлал муутай, найдваргүй болох эрсдэлтэй байна. Шинжилгээний төлбөр цаг хугацаандаа төлөгдөхгүй найдваргүй авлага үүсч байгаад дараах уламжлалт эрсдэл нөлөөлж байна Үүнд:

- Харилцагчийн захиалгаар хийгдэх шинжилгээний ажлын захиалгын мэдээллийг бүртгэх, үе шатыг хянах ЛИМС программ нь мэдээллийг хадгалах нууцлалын тохиргоогүй, инженер техникийн болон бусад ажилтнуудын хувьд захиалгын хуудасны дугаарын дагуу тухайн захиалагчийн шинжилгээний, эцсийн болон үе шатны үр дүнг мэдэх боломжтой байдаг тул мэдээлэл алдагдах, улмаар шинжилгээний хариугаа авалгүй орхидог.
- Шинжилгээний дүгнэлтийг батлах, гарын үсэг зурах эрх бүхий зарим ажилтнуудын шийдвэрээр танил тал, холбоотой харилцагч нарт төлбөрийн эцсийн тооцоо хийгээгүй байхад шинжилгээний хариуг урьдчилж гаргаж өгөх тохиолдол урд онуудад гарч байсан.
- Компанийн санхүүгийн ажилтнууд нь авлага, өглөгийн үлдэгдлийг тухай бүр нь тооцоо нийлж баталгаажуулдаггүй, Тайлант онд тооцооны үлдэгдэлтэй нийт 315 харилцагчаас (хуримтлагдсан авлагатай харилцагчийг оруулаад) зөвхөн 18 харилцагчтай тооцоо нийлж, акт үйлдсэн байна.
- Нэг байгууллагын олон харилцагч нарын өгсөн захиалгын авлагыг нэгтгэн нэг харилцагчаар буюу байгууллагын нэрээр нягтлан бодох бүртгэлд тусгагдгаас үүссэн авлага, өглөгийг хариуцах эзнийг тогтооход хүндрэл учирдаг.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.10 дугаар заалт: "Аж ахуйн нэгжийн дарга нь үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох; эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийн тулд үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах үүрэгтэй" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дугаар заалт: "Ерөнхий нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж оршин байх, эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

1. Шинжилгээний ажлын эцсийн болон үе шатны мэдээллийн нууцыг хадгалах аргачлал болон системийг боловсруулж үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
2. Санхүүгийн албанаас төлбөрийн тооцоо хийснийг баталсны дараа шинжилгээний хариуг өгч хэвшүүлэх, хяналтыг сайжруулах;
3. Шинжилгээний төлбөр тооцоотой холбоотой авлагын үлдэгдлийг сар бүрийн эцэст гаргаж хяналт тавин төлөх хугацааг тодруулж байх, авлагыг барагдуулах арга хэмжээг тухай бүр авах, харилцагчийн авлага, өглөгийн үлдэгдлийг улирал болон жилийн тайлангийн эцэст тооцоо нийлж, акт үйлдэж баталгаажуулж байх;
4. Захиалгыг ЛИМС болон санхүүгийн программд бүртгэхдээ захиалагчийн нэр хаяг, холбогдох мэдээллийг системд тодорхой хадгалж захиалга тус бүрийг тусад нь бүртгэж байх;
5. Урд онуудад үүссэн авлага өглөгийн үлдэгдлийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх;

**2. Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Захирлын 2021 оны 11 сарын 24-ний өдрийн А/88 тушаалаар Засгийн газрын 2013 оны 44 тоот тогтоолын дагуу уул уурхайн бүтээгдэхүүний экспортын шинжилгээ хийж, байгууллагын үйл ажиллагааны хөгжлийн төслийг боловсруулсан нэр бүхий ажилтнуудад нийт 26.0 сая төгрөгийн урамшуулал олгохдоо 6.5 сая төгрөгийн НДШ-ийг суутган тооцоогүй, төвлөрүүлээгүй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дүгээр заалт: “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх үүрэгтэй” гэж заасантай нийцээгүй, Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ажилтнуудад олгосон урамшууллын нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцож, Нийгмийн даатгалын хэлтэстэй тооцоо хийх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	/мянган төгрөгөөр/											
					Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Геологийн төв лаборатори ТӨҮГ	АХГ-2022/57/НА-СТА-ТӨА	СХД-ийн шүүхийн шийдвэрээр үндэслэлгүйгээр ажлаас халагдсан нь тогтоогдсон 2 ажилтны нөхөн төлбөр 26,278.8 мянган төгрөгийг байгууллагаас төлснийг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас авах авлагаар бүртгэсэн.	Буруутай этгээдийн нэр дээр авлагыг шилжүүлэн бүртгэж залруулах	1	26278.8	1	26278,8								
2			УУХҮЯам, Бодь электроник ХХК-ийн хооронд байгуулагдсан 2018 оны 03/2288 тоот гэрээний дагуу нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн удирдлагын программ өнөөдрийг хүртэл ашиглалтад ороогүй, нягтлан бодох бүртгэлд туссан биет бус хөрөнгийн дүнг элэгдүүлэн бүртгэж байна.	Программыг ашиглалтад оруулах албан шаардлага	1	32,238.8					1	32,238.8				
3			Лабораторийн шинжилгээний мэдээллийг боловсруулах программ болон үйл ажиллагааны нууцлалын систем хангалтгүй, төлбөр тооцоо хийгээгүй байхад шинжилгээний хариу, дүгнэлтийг харилцагчид гаргаж өгдөг, тайлант хугацаанд үүссэн өглөг авлагын 50 хүрэхгүй хувийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулдаг зэргээс авлага өсч найдваргүй болох эрсдэл нэмэгдэж байна.	Мэдээллийн системийн нууцлалыг хангах, харилцагч нэг бүртэй тооцоо нийлж байх зөвлөмж өгөх	1									1	-	
4			Өнгөт чулууны цехийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний өртөг болон борлуулах үнэ тооцох аргачлал байхгүй 2016 оноос хойш үнийг шинэчлээгүй, зах зээлийн үнийг харгалзаж үздэггүй, нийт 4,025.5 мянган төгрөгийн өртөгтэй, бүтээгдэхүүнийг 2,681.8 мянган төгрөгөөр буюу өртгөөс нь бага үнээр зарж борлуулсан.	Өртөг, үнэ тооцох журам боловсруулах, өртгөөс нь бага үнээр борлуулалт хийхгүй байх	1	4,025.5						1	4,025.5			

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5			Захирлын 2021 оны 11 сарын 24-ний өдрийн А/88 тушаалаар ажилтнуудад 26,000.0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо НДШ-ийг суутган тооцоогүй, төвлөрүүлээгүй байна.	НДШ нөхөн тооцох зөвлөмж	1	6,500.0								1	6,500.0
<b>ДҮН</b>					5	69,043.1	1	26,278.8			2	36,264.3		2	6,500.0
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															
6	Геологийн төв лаборатори ТӨҮГ	АХГ-2022/57/НА-СТА-ТӨА	Геологийн төв лаборатори ТӨҮГ нь тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 248,600.0 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	Шилэн дансны хуулийг мөрдөж ажиллах	1	248,600.0								1	248,600.0
7			Компанийн үйл ажиллагаанд хэрэглэх 26,814.0 мянган төгрөгийн үнэ бүхий дээж сэгсрэгч тавцан бүхий ширээ, тоног төхөөрөмжийг үнийн харьцуулалт хийлгүй шууд худалдан авсан.	ТБОНӨХБАҮХА хуулийг мөрдөж ажиллах	1	26,814.0					1	26,814.0			
<b>ДҮН</b>					2	275,414.0					1	26,814.0		1	248,600.0
<b>НИЙТ ДҮН</b>					7	344,457.1	1	26,278.8			4	63,078.3		3	255,100.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒᠒ оны ᠐3 дугаар сарын 15 № 567/АХС᠒᠐᠒3  
АХС-᠒᠐᠒᠒/᠑7/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын дэргэдэх өнгөт чулууны цехийн үйлдвэрлэж байгаа хөөрөгнөөс бусад бүтээгдэхүүний өртөг болон борлуулах үнэ тооцох журамласан аргачлал, эрх зүйн акт байхгүй Бүтээгдэхүүний өртөгт шууд хөдөлмөрөөс гадна шууд материал болон үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг тооцож оруулах аргачлал байхгүй. 2016 оноос хойш бүтээгдэхүүнийг борлуулах үнийг шинэчлээгүй, зарж борлуулахдаа зах зээлийн үнийг харгалзаж үздэггүй, нийт 4,025,500.00 төгрөгийн өртөгтэй, чүнчигноров чулуутай 4 ширхэг хөөрөг, гоёл чимэглэлийн зүйлсийг 2,681,800.00 төгрөгөөр буюу өртгөөс нь бага үнээр зарж борлуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл Аж ахуйн нэгжийн захирлын эд хөрөнгийн эрх үүрэг 20.9 "улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох," 20.10 "эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах," гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өнгөт чулуун цехийн өртөг тооцох болон үнэ тогтоох аргачлалыг боловсруулж мөрдөх, бүтээгдэхүүнийг борлуулахдаа зах зээлийн үнийг харгалзан өртгөөс нь бага үнээр зарж борлуулахгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын захирал О.Даваасамбуу, Ерөнхий нягтлан бодогч Я.Оюунсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

НИЙСЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Т.СУГАРСҮРЭН

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-204230

4006109  
0019120396

Z:\Alban Shardlaga\2022\03\5 Auditin 2 Gazar-256.Docx

0001081495



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 568 / АО/SDOS3  
АХТ - 2022/57/НА - СТА - ТВА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Тайлант онд 26,814,000.00 төгрөгийн үнэтэй дээж сэгсрэгч ширээ тоног төхөөрөмжийг үнийн харьцуулалт хийлгүйгээр шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр босго үнийг тогтооно", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад "Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртөг нь бараа, үйлчилгээний хувьд дээд хязгаар нь 70 сая төгрөг, доод хязгаар нь 20 сая төгрөг, ажлын хувьд дээд хязгаар нь 100 сая, доод хязгаар нь 20 сая төгрөг байна" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын захирал О.Даваасамбуу, Ерөнхий нягтлан бодогч Я.Оюунсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


АУДИТЫН МЕНЕЖЕР

НИЙСЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Т.СУГАРСҮРЭН



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тайруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-255.Docx

0001081493



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 08 дугаар сарын 15 № 569/АУИСОСЗ  
АХГ-2022/57/НА-СТА-ТӨА  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

УУХҮЯам, Бодь электроникс ХХК-ийн хооронд байгуулсан 2018 оны 03/2288 тоот гэрээний дагуу нийлүүлэгдсэн чулууны насжилтыг тогтоох, Геологийн төв лабораторийн шинжилгээний үр дүнг боловсруулах, лабораторийн тоног төхөөрөмжийн мэдээллийг нэгдсэн удирдлагаар хангах зориулалт бүхий 32,238,800.00 төгрөгийн үнэ бүхий 2 программ хангамж нь өнөөдрийг хүртэл тохиргоо бүрэн хийгээгүйгээс үйл ажиллагаандаа ашиглаж эхлээгүй, хүлээж авсан акт байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4.1 Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй: 1/ өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүрэг: 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Программ хангамжийн тохиргоог хийлгэж, ашиглалтад оруулах, гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын захирал О.Даваасамбуу, Ерөнхий нягтлан бодогч Я.Оюунсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

НИЙСЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Т.СУГАРСҮРЭН

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бяга тойруу-2, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

110.10.10.20/Bichig\_Nereg/Alban\_Shaardlaga/2022/0315\_Auditin\_2\_Gazar-254.Docx  
9006109  
9019120396

0001091505